

## ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТАГ ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСҮҮД

Б. Балдоо

Сүүлийн 20-30 жилд улс орнууд сонгож авсан нутгуудтаа эдийн засгийн хөгжлийг хурдасгах зорилгоор эдийн засгийн ба худалдааны чөлөөт бүсүүд байгуулах болсон байна.

Ер нь татвар үл төлдөг анх түрүүчийн бүс өнгөрсөн зууны эцсээр Гданьскад үүсч, манай зууны 30-40-өөд онд АНУ болон бусад улсад гаалийн чөлөөт бүсийн тухай хууль гарч, 50-иад оны эцсээр экспортын үйлдвэрлэлийн бүс Ирландийн онгоцны буудал Шеннонд байгуулагдаж, 70-80-аад онд энэ талаархи олон улсын хууль тогтоомж ч бий болжээ. Тэгээд эдийн засгийн чөлөөт бүс янз бүрийн оронд дэлгэрч эдийн засгийн туршилтын талбарууд болох боллоо. Одоо үед бараг 80-аад оронд хэдэн зуун эдийн засгийн чөлөөт бүс ажиллаж байгаа гэсэн тооцоо байдаг ажээ.

Онцлог нутгуудтаа хөрөнгө оруулалт, дэд бүтцийг төвлөрүүлэх үүднээс голдуу хөгжиж буй энэ аргыг хэрэглэдэг боловч хөгжилтэй орнууд ч өөрийн хоцрогдож ирсэн нутгийн хөгжилд дэм үзүүлэх зорилгоор ийм бүсүүдийг сонгон байгуулж ашиглах болсон байна. Өнгөрсөн арав орчим жилд Зүүн өмнөд Азид чөлөөт бүсийн бум буюу өрнөл гэгч боллоо. Ойрмогос эдийн засгийн либералчлах явдал социалист, хуучин социалист байсан оронд дэлгэрч эхлэхэд Зүүн хойт Азид түүний хувь хүртээл үзэгдэх болсон. Хятад, Умард Солонгос, Орос улс өөрсдөдөө эдийн засгийн чөлөөт бүс байгуулах санал дэвшүүлэн, зөвшөөрөн хөхүүлэхийн хамт бас гурван улсыг хамарсан бүс нутгийн төлөвлөгөөг ч боловсруулах болжээ. Эдгээр чөлөөт бүсийн заримын үйл ажиллагаанаас товч дурдъя.

Оросын Холбооны улс 1990 онд эдийн засгийн чөлөөт бүс II-ийг тодорхойлон гаргаж бүх орон даяараа дэлгэрүүлэх болжээ. Сүүлийн жилүүдэд Орос орны улс төр, эдийн засгийн байдал тогтворгүй байгаагийн улмаас эдийн засгийн чөлөөт бүсүүдийн олонхи нь үйл ажиллагаагаа өрнүүлж чадахгүй нэр төдий байгаа ажээ.

Байгалийн баялгийн нөөцийг ашиглах зэрэг хялбархан орлого олж болох тодорхой салбарыг эс тооцвол Орост их хэмжээний капитал оруулах нь ашигтай эсэхэд гадаадын хөрөнгө оруулагчид эргэлзсээр байна. II чөлөөт бүсийн 4 нь Оросын Алс Дорнодод байдаг бөгөөд тэдгээр нь Чита, Сахалин мужууд, Приморийн хязгаар, Еврейн автономит муж юм.

Приморийн хязгаарын засаг захиргаа "Их Владивостокийн эдийн засгийн чөлөөт бүсийн" /Находка хотын районыг өөртөө багтаасан/ үйл ажиллагааг өрнүүлэхэд анхаарал тавьж байна. Энэ чөлөөт бүс нь Приморийн хязгаарын өмнөд хэсэгт орших бөгөөд дорнод талдаа Восточный боомт, өрнөд талдаа Хасан нуур хүрч, Умард Солонгос, Хятадтай хиллэдэг өргөн их нутаг дэвсгэрийг хамарч байгаа юм. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн нвээл дор Японы техникийн зөвлөх пүүсүүдийн холбооноос энд судалгаа явуулж 1991 оны сүүлчээр дууссан юм. Сонгож авсан нутаг дэвсгэрийг эдийн засгийн чөлөөт бүс болгон тодорхойлох төлөвлөгөөг ОХУ-ын Засгийн газраас хараахан батлаагүй байна.

"Их Владивостокийн эдийн засгийн чөлөөт бүсийн" /ИВЭЗЧБ/ зорилго нь Ази тивийн орнуудтай худалдаа хийх, тэднээс хөрөнгө оруулах явдал юм. 1992 оны I дүгээр сарын I-ээс Владивосток хотыг гадаад худалдааны чөлөөт боомт болгож, гадаадын ба дотоодын хүмүүст урьд хориотой байсан зүйлсийг халснаас хойш гадаадынхнаас Оросын Алс Дорнодын эдийн засгийн бололцоотой танилцах үйл ажил өрнүүлсэн боловч ийнхүү улс орны тогтворгүй байдлаас болоод бүс нутагт

ажиллахыг хүссэн олон потенциал түншийн идэвх суларсан байна. ИВЭЗЧБ нь Владивосток хотод төөлөрсөн эдийн засгийн чөлөөт бүсэд биет болон дэг журмын дэд бүтцийг байгуулах интеграц төлөвлөгөө бөгөөд энэ төлөвлөгөө нь зөвхөн Приморийн хязгаараар барахгүй мөн Хятад, Умард Солонгосын хилийн бүсүүд, Монголыг ч хөгжүүлэхэд багагүй нөлөөлөх ёстой гэж тооцогдсон ажээ.

ИВЭЗЧБ нь орт, экспортын үйл явцын аль алиныг эрхлэх бүс бөгөөд далайн чөлөөт боомт, олон төрний үйлчилгээний баазад тулгуурлан ажиллах юм. Тус бүс нь 3 дэд бүстэй: боловсрол, эрдэм шинжилгээ, үйлчилгээ бүхий, бүсийн төв штаб байрлах Владивосток хот, өргөн масштабтай, эрчимтэй үйлдвэрлэлийг дагнан эрхлэх Находка хот, их ач холбогдолтой дэд бүтэц, тээврийн сүлжээ байхгүй боловч аж үйлдвэр, хөдөө аж ахуй, загас агнуур, хүнсний үйлдвэрлэлийг хил залгаа Хятад, Умард Солонгостой хоршин явуулж болох давуу талтай Хасан хотоос тус тус бүрдэх юм.

ИВЭЗЧБ-ийн хөгжил нь 3 шаттай хэрэгжихээр тооцогдсон I шатанд, байгаа нөөцийг баримжаалсан таваарыг экспортод зориулан үйлдвэрлэх, бүтээгдэхүүнийг хилийн чанадад борлуулан, өөрийн дэд бүтцэд хэрэгтэй зүйлсийг оруулах, II шатанд, илүү амжилттай болсон олон янзын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, импортоос хамаарах хамаарлыг багасган, барааны чанарыг дээшлүүлэх олон улсын стандартад ойртуулах, III шатанд, дотоодод хэрэглэх, экспортод гаргах бүтээгдэхүүний аль алины үйлдвэрлэлийг өндөр технологийн төвшинд хүргэн дээшлүүлэх зорилтуудыг шийдвэрлэхээр төлөвлөгдөж байгаа ажээ.

БНХАУ нутгийнхаа Зүүн хойт хэсэгт дотоод, гадаадаас хөрөнгө оруулах, худалдааг хөгжүүлэхийн тулд Манжоули, Суйфеньхе, Хуньчин, Кокука гэсэн 4 хотыг эдийн засгийн тусгай бүс болгон сонгон тодорхойлсон байна. Төв Засгийн газар нь орон нутгийн Засгийн газруудын автономн эрхийг өргөтгөн, санхүүгийн талаар урамшуулж, дэд бүтцийг сайжруулан, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд зээл олгох зэргээр дэмжиж байгаа ажээ.

Дурдсан чөлөөт бүсүүд ойролцоо хугацаанд сонгон тодорхойлогдсон боловч өөр өөрийн онцлогтой юм.

Монгол, Орос улсын хилээс холгүй байгуулагдсан Манжоулийн эдийн засгийн бүс нь Өвөр Монголын нутагт оршдог бөгөөд тэнд худалдааны үйл ажиллагаа өрнөж 20 гаруй орны төлөөлөгчидтэй холбоо тогтоосон байна. Энэ бүсэд 70 орчим худалдааны компани бизнес эрхэлж жилд 4 сая орчим тонн барааны гүйлгээ хийж байна. Тус хот нь гаалийн алба, олон улсын суудлын галт тэрэгний буудал, ачаа хадгалах газар, олон улсын холбооны үйлчилгээтэй бөгөөд зочид буудал, ресторан, дэлгүүр, тойрон аяллын баазуудыг одоо байгуулж байгаа ажээ.

Хар мөрөн муж, Орос улсын хоорондын хил дээр, Уссурийск хотоос холгүй орших Суйфеньхе хотод эдийн засгийн шинэ бүсийг байгуулж байна.

Түмэн голын бэлчээр дээр орших 170 мянган хүн амтай Хуньчин хотод эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар 1991 оны II дүгээр сард сонгон тодорхойлжээ. Орон нутгийн захиргаа нь бүсийн автономн эрх, гадаадын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжих явдлыг баталгаатай болгожээ. Үйлдвэр хөгжүүлэх 5, 6 хавтгай дөрвөлжин километр эдлэн газрыг дотроо багтаасан чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө өнөө үед боловсрогдож байгаа юм байна. Аж үйлдвэрийн гол сектор нь нэхмэл, хүнс, барилгын материал, өргөн хэрэгцээний барааны үйлдвэрлэл, электроник зэрэг хөнгөн үйлдвэрийг багтаах бөгөөд Хуньчинийг Түмэн хоттой холбох төмөр зам баригдаж байгаа ажээ.

Амар мөрний ойролцоо. Кокука хотод худалдааны чөлөөт бүс байгуулжээ. Оросыг дайран Амар мөрнөөр Япон далайд гарахыг хятадуудад зөвшөөрсөн хэлэлцээрийг үндэслэн тэд Амар мөрний эргээр усан боомтуудыг барих боломжтой болсон. Хүнсний зүйл, нүүрс, мод,

нефть, өргөн хэрэглээний барааны худалдаа жилд 300 мянган тоннд хүрч зарим хэсэг нь Японд гарч байна. Урьд Японтой зөвхөн Далянь боомтоор харилцаж байжээ.

БНАСАУ Түмэн голын бэлчээрийн Ражин-Сонбоны хэсэгт 621 хавтгай дөрвөлжин километр нутгийг эдийн засгийн ба худалдааны чөлөөт бүс болгохоор 1991 оны 12 дугаар сард сонгон тодорхойлсон байна. Орос, Хятадтай хил нийлсэн энэ нутагт чөлөөт бүс байгуулснаар БНАСАУ Зүүн хойт Ази уруу зам харилцааны ба худалдааны үүд нээх зорилт тавьжээ. 130 гаруй мянган хүн амтай энэ бүсэд хими, усан онгоцны засвар, нефть боловсруулалт, хүнсний үйлдвэр, дулааны цахилгаан станц зэрэг нэлээд үйлдвэрийн газар байдаг. Бүс дэх Ражин, Сонбоны усан боомтоос холгүй орших Чонжинийг мөн худалдааны чөлөөт боомт болгон тодорхойлжээ. Одоо Ражин-Сонбон хоёр боомтын жилийн нийлбэр хүчин чадал II сая тонн байгааг 20 сая тоннод хүргэн дээшлүүлэхээр төлөвлөж буй. Гэвч БНАСАУ-д капитал дутагдалтайгаас боомтуудыг өргөтгөх төлөвлөгөөг хязгаарлагдмал нөөц дээр үндэслэхээс өөр аргагүй байгаа болно.

Тус улсын Засгийн газар нэгэнт байгаа бааз дээр тулгуурлан металл, хими, машин, усан онгоц, уул уурхаа, хөнгөн үйлдвэрийн газруудыг Ражин-Сонбоны бүсэд хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Тэгэхдээ бүс нутагт гадаадын технологи, капиталыг ашиглахад найдвар тавьж, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрт хандаж гадаадаас хөрөнгө оруулах төлөвлөгөө боловсруулахад нь туслахыг хүссэн байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Хятад, Умард Солонгос, Орос гурван улсын хил нийлсэн нутаг дэвсгэрүүдийг өөртөө багтаасан бүс нутгийн эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах асуудлыг урагшлуулахад туйлах нөлөө үзүүлэх гэж чармайж байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс "Түмэн гол нутгийн хөгжлийн хөтөлбөр" /ТГНХХ/ нэртэй урт хугацаанд хэрэгжих асар том арга хэмжээг санаачилсан бөгөөд түүнд 30 тэрбум ам. долларын зардал шаардагдах юм. ТГНХХ нь "Түмэн голын эдийн засгийн бүс" /Хуньчин-Посьет-Ражин/ ба "Түмэнгийн эдийн засгийн хөгжлийн бүс" /Тяньжин-Владивосток-Чонжин/ гэсэн хоёр бүсийг лууны өмнө өөртөө багтаахаар төлөвлөгдөж байгаа аж. ТГНХХ-ийн Зөвлөл, захирлуудын төслийн товчоогоос ажлын хэсэг байгуулж түүний анхны чуулганыг 1992 оны 4 дүгээр сард Бээжинд хуралдуулав. Чуулганаас 18 сарын ажлын төлөвлөгөөг зарлаж, 3, 5 сая ам. долларын төсвийг баталжээ. Энэ хөрөнгө нь үндсэндээ судалгаанд зориулагдах юм. Энэхүү эдийн засгийн бүсийг байгуулан ажиллуулахад Монгол улс идэвхтэй оролцохыг эрмэлзэж байгаа /Хөтөлбөрийн менежментийн хороонь гишүүн болсон/ бөгөөд Монголыг мөнхүү эдийн засгийн бүстэй холбох олон улсын төмөр замын харилцааны сүлжээг хөгжүүлэх олон талын хамтын ажиллагаа, цаашид Түмэн гол нутгийг Европтой холбох хуурай замын гүүрийг Монголын нутгийг дайруулан тавих асуудлыг ихэд сонирхож байгаа билээ.

Одоогоор Түмэн голын сав газарт байгуулах эдийн засгийн бүсийн бодит хил хязгаарыг тогтоох зэрэг шийдвэрлэх олон асуудал буй билээ.

Оросын Алс Дорнод, Зүүн хойт Хятад, БНАСАУ-ын умард хэсэгт эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулагдан ажиллэн эхэлж байгаа нь эдгээр улсын гадаад худалдааг өргөтгөх, гадаадаас хөрөнгө оруулахад чухал нөлөө үзүүлэх болно.

Зүүн хойт Азийн бүс нутгийн худалдааг авч үзвэл 1985 оноос 1990 онд 63 хувиар өсч 40 тэрбум байснаа 65 тэрбумд хүрчээ. Бүс нутгийн худалдаанд Япон, Өмнөд Солонгос, Хятад зонхилох үүрэг гүйцэтгэж байна. Үүний хамт хүйтэн дайн дуусвар болсны дараагаас Өмнөд Солонгос, Хятадын хооронд, ТТУХН, Өмнөд Солонгосын хооронд худалдааны харилцаа шинээр тогтож Хятад, ТТУХН-ын хоорондын худалдаа өсчээ.

Хятадын зүүн хойт мужууд худалдааны бүтцийн хувьд янз янз юм. Далянь боомт бүхий Ляонин муж нь экспортоор Гуандун мужийн

дараа орох бөгөөд Хар мөрөн мужийнхаас 5 дахин Жилин мужийнхаас 7 дахин илүү зүйл экспортолдос. Сүүлчийн дурдсан хоёр муж нь далайд гарцгүй учраас зөвхөн хил залгаа ОХУ, БНАСАУ-тай худалддаг хийдэг.

Зүүн хойт Хятад, Оросын хоорондын худалдаа хурдан өсч, 1990 онд 1.3 тэрбум долларт хүрчээ. Оросын Алс Дорнод, ОХУ-ын нийт худалдаанд бэсгэхэн үүрэг гүйцэтгэж 1988 онд түүний бүх экспортын дөнгөж 1.8 хувийг эзэлж байв. Оросын Алс Дорнодос голдуу мод, загас, нүүрс экспортод гаргадаг.

Бүс нутгийн дурдсан орнууд гадаадаас хөрөнгө оруулах асуудлыг чухалчлан үзэж дотооддоо зохих нөхцөлийг буй болгох талаар анхааран ажиллаж байна.

Хуучин ЗХУ 1987 оноос эхлэн холимог буюу хамтын үйлдвэр, дан гадаадынхны өмчилсөн компаниуд байгуулахыг зөвшөөрч 1991 оны сүүлчээр тэдгээр нь 4 мянгад хүрч 7 тэрбум рублийн хөрөнгөтэй байв. Гэвч тэдгээрийн гурван нэг орчим нь үйл ажиллагаагаа хэрэг дээр дөнгөж эхэлж, олонх нь худалдаа үйлчилгээг эрхэлж байсан байна. Оросын олонх үйлдвэр компани дэд бүтэц илүү хөгжсөн, хүн ам олонтой нутгийн өрнөд хэсгийн Москва, Санкт-Петербург зэрэг хотод ажиллаж байв. Зүүн хойт Азиас ТТУХН-д оруулж буй хөрөнгө нь Өрнөд Европ, АНУ-аас оруулж байгаатай харьцуулбал тун бага юм.

1991 оны дундуураас Оросын Алс Дорнодод Япон, АНУ, Өмнөд Солонгос, Хятад, Умард Солонгостой хамтарсан 60 шахам үйлдвэр, аж ахуйн газар байгуулагдсан. Тэдгээрийн дотор ой үржүүлэх, мод боловсруулах үйлдвэрээс гадна хоолны газар, зочид буудал зэрэг үйлчилгээний газар, худалдааны компани орсон байна.

БНАСАУ гадаадын хөрөнгийг 1987 оноос оруулах болсон бөгөөд мөн онд ЗХУ-тай хөрөнгө оруулах тухай гэрээ байгуулжээ. 1990 оноос Япон улс Умард Солонгосын компаниудтай хамтран ажиллах болж энэ ажилд Японд суугаа солонгосчууд чухал үүрэг гүйцэтгэж байв.

БНХАУ гадаадаас хөрөнгө оруулах явдлыг 1980-аад оноос анхаарч иржээ. 1990 оны эцэст нийтдээ 40 гаруй тэрбум долларын хөрөнгө оруулалтаар 29 гаруй мянган төсөл хэрэгжүүлэхээр батлагдсаны 19 тэрбум доллар их нь бодитой хэрэгжээд байгаа ажээ. Энэхүү хөрөнгө оруулалтын хүрээнд ажилласан 14 мянга гаруй компани 2 сая гаруй ажилын байрыг буй болгожээ.

Өнөөгийн олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны практикт чөлөөт бүсийн тухай нэгдмэл ойлголт хэдийнээ бүрэлдэн тогтжээ. Эдийн засгийн чөлөөт бүс гэдэг бол алив орны дотор сонголт хийж тусгайлан гаргасан нутаг дэвсгэр бөгөөд тэнд тэрхүү орны бусад нутагт байдгаас ялгаатай хууль зүйн дэг журмыг Засгийн газраас тогтоодог байна. Энэ дэг журам нь доогуур тогтоосон гаалийн татвар хураамж, ашиг орлого ба үл хөдлөх хөрөнгөнөөс хураах хөнгөлттэй татвар, хөдсний хөдөлмөр чөлөөтэй хэрэглэх хууль, гадаадын хөрөнгө оруулах тусгай нөхцөл зэргийг багтаадаг ажээ. Хөрөнгө оруулагчдыг чөлөөт бүсэд татахын тул уг бүсээ олонт йхон дэд бүтэцтэй байлгах талаар Засгийн газраас онцгой хүчин чармайлт тавьдаг байна.

Сүүлийн жилүүдэд байгуулагдан ажиллаж байгаа эдийн засгийн чөлөөт бүсүүдийг тодорхой төрлүүдэд хуваан авч үздэг ажээ. Орчин үед хөгжиж байгаа орнууд, хөгжингүй орнууд ялгаагүй эдийн засгийн чөлөөт бүсийг дэд бүтцийн хөгжлийг төвлөрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтанд түлхэц өгөх хэрэгсэл болгон ашиглах нь нийтлэг болсон байна. Тусгайлан гаргасан нутаг дэвсгэрийн хэрэгцээнд илүү сайн тохирохуйц эдийн засгийн чөлөөт бүсийн төрлийг сонгон авах явдал нь олон хүчин зүйлийг хамаардаг байна. Тэдгээр хүчин зүйл нь газар нутгийн байршил, одоо байгаа, цаашдаа бүрдэх бололцоотой дэд бүтцийн хөгжил, үйлдвэржүүлэлтийн төвшин, үйлчилгээ, хууль зүйн /хэв журмын/ тогтолцоо зэргээс бүрдэх юм.

Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг дараах төрлүүд болгон бүлэглэж, тодорхой район, улсаар төлөөлүүлэн авч үздэг байна. Үүнд:

1. Чөлөөт боомт худалдааны чөлөөт бүс /Гонконг, Сингапур/.

Энэ төрлийн бүс нь өндөр хөгжсөн жижиг оронд бий болж гадаад том зах зээлээр хүрээлэгдэж байдгаар өвөрмөц юм. Тэнд импорт, экспортын татвар хамгийн бага буюу огт үгүй, чамгүй зүгширсэн үйлчилгээний салбартай бөгөөд энэ салбар нь ачих буулгах үйлчилгээ, банк, даатгал зэрэг олон улсын бизнесийн арилжааг дэмжих чадвартай юм.

2. Эдийн засгийн чөлөөт бүс /Шэньчжен, Батам/. Энэ бүс асар том улсуудын нутаг дээр байгуулагдсан учир энд тогтоосон хөнгөлөлттэй /преференциал/ татвар, түүхэн үзүүлэх бусад хүчин зүйл нь бүс нутгийн хөгжлийг урагшлуулах баталгаа болдог. Бүсэд үйлдвэрлэлийг явуулахад мэргэжлийн үйлчилгээ чухал тус үзүүлдэг байна.

3. Экспортын үйл явцыг эрхэлдэг бүс /Өмнөд Солонгос, Тайвань, АСЕАН/ Энэ систем нь мэргэжилтэй ажилчдаар сайтар хангагдсан нутагт оршдог бөгөөд экспортын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хэрэгцээтэй зүйлсийг татваргүйгээр оруулахыг зөвшөөрдөг байна.

4. Худалдааны чөлөөт бүс /Панам, Абу Даби/ Зам харилцааны гол зангилаа газар, үндсэн зах зээлийн ойролцоо оршдог энэ бүсэд реэкспортод зориулагдсан бүх барааг татвараас чөлөөтэй оруулахыг зөвшөөрдөг байна.

5. Импортны үйл явцыг эрхэлдэг бүс /АНУ/ Хожим үйлдвэрлэл явуулахад ашигладаг бүх материалыг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулахад боряу талтанд зориулан бүсээс гаргах хүртэл татвараас чөлөөлдөг байна. Ийм төрлийн бүсүүд нь өргөн дэлгэр нутаг хамарсан, гол гол зах зээл бүхий АНУ-ын хэд хэдэн муж улсад байгуулагджээ. Ийм төрлийн бүс нь бүсийнхэнд их хэмжээгээр бараа оруулж, тээврийн хөлсийг бууруулж, үйлдвэрлэсэн бүх барааг эцэслэн зарах хүртэл гаалийн татварын төлбөрийг хойшлуулах бололцоо олгодог ажээ.

6. Импорт, экспортын үйл явцыг эрхэлдэг бүс /Хятад, АСЕАН/ Бүсэд оруулж байгаа бүх барааг татвараас чөлөөлнө. Харин улс орныхо дотоодод худалдаалахаар бүсээс гаргах бараанд татвар ногдуулна. Их хэмжээний ажиллах хүч бүхий нутаг дээр эдийн засгийн үйл ажиллагааг төвлөрүүлэх зорилгоор ийм стратегийг ашигладаг байна.

Эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай ажиллуулахад зайлшгүй шаардагдох тодорхой нөхцөл бүрдүүлж, тодорхой зорилго тавьдаг байна.

Эдийн засгийн чөлөөт бүсийг зөвхөн Азид ч бус, дэлхий даяар олноор байгуулах болжээ. Тэдгээртээ тоотой нь голдуу шинээр үйлдвэржсэн эдийн засгууд /ШҮЭЗ/, Хятад, АСЕАН-ын орнуудад амжилттай ажиллаж байгаа юм. Эдийн засгийн чөлөөт бүс амжилттай ажиллахад нөлөөлөх олон хүчин зүйлийн дотроос хоёр хүчин зүйл голлох бөгөөд энэ нь нэгд, өөрийн орны ба гадаад орны хөрөнгө оруулагыг өөртөө татах чадвар, хоёрд, зайлшгүй шаардлагаг дэд бүтцийг улсын санхүүжүүлэлт буюу хөгжилд зориулсан албан ёсны тусламж /ОрМ/ -аар бий болгох явдал юм гэж үздэг байна.

Эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай ажиллуулахад дарзах хүчин зүйл зайлшгүй шаардагддаг байна. Эдгээр нь:

1. Эдийн засгийн чөлөөт бүсийн талаар төв засгийн газраас явуулах ял тод бодлого.
2. Засгийн газраас байгуулсан дэд бүтэц.
3. Газар, ачих буулгах зэрэг үйлчилгээний зүгширсэн тогтолцоо.
4. Өрсөлдөөний үндсэн дээр цалинждаг мэргэжлийн ба мэргэжлийн бүс ажиллах хүч.
5. Банк, даатгал зэрэг үйлчилгээний аж ахуй.
6. Ажиллахаар нийлжин ирэгсдэд зориулсан сайн чанарын зорилго сууц, төв тухай бий болгох бусад зүйлс.
7. Эдийн засаг, улс төрийн тогтвортой нөхцөл.

8. Хууль зүйн буюу дэг журмын хатуу систем болно.

Эдгээр хүчин зүйлсээс нэг буюу хэд хэдэн нь дутагдвал эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг хойш татна. Жишээ нь: Индонезийн Багам аралд дэд бүтээн хангалтгүй. Шри Ланкийн Коломбод улс төрийн байдал тогтворгүй, Дорнод Малайзид ажиллах хүчин дутагдалтай. Төв Индонезид үйлчилгээний салбар суя хөгжилтэй байснаас тэдгээр нутагт байгуулсан чөлөөт бүсүүд тухайн үедээ оллогтой ажиллахгүй байсан ажээ.

Эдийн засгийн чөлөөт бүсүүдийн зорилго нь янз бүрийн улсуудын хооронд төдийгүй, нэг улсын янз бүрийн бүс нутгуудын хооронд өөр өөр болж байдаг. Нийтлэг гол зорилгуудаас дараа дурдсан хэдийг онцолж болно. Үүнд:

1. Бүс нутгийн хөгжлийг хүчтэй болгох.
2. Гадаадын хөрөнгө оруулалтанд түлхэц үзүүлэх.
3. Шинэ технологийг нэвтрүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх.
4. Дэд бүтцийг хөгжүүлэн ажиллах хүчний мэргэжлийг өндөржүүлэх.
5. Эдийн засгийн шинэ системийг туршиж үзэх гэх зэрэг болно.

Амжилттай ажиллаж байгаа эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг Тайвань, БНХАУ-ын Шэньчжэн, Сингапурийн жишээ эн дээр товч дурдъя.

Тайвань бол экспортын үйл явцыг эрхлэх бүсийг амжилттай ашигласан анхны орнуудын нэг юм. Дурьдсан чөлөөт бүсийг шинэ үйлдвэрүүдийг байгуулах хэрэгсэл болгон ашиглаж ажлын байруудыг бий болгох, экспортоос гадаад солилцсон ашиг олох талаар үр дүнд хүрсэн юм. Тайваньд анхны экспортын үйл явцыг эрхлэх бүсийг 1966 онд Такао, дараа нь 1971 онд Нанко, Дайчуд байгуулжээ. Тайваний эдгээр бүс нь 174 гектар газарт байрладаг. 70 мянган хүн ажилладаг юм байна.

Тайвань эдгээр бүсийг байгуулахдаа хэд хэдэн зорилго тавьсан юм. Үүнд: дотоодын ба гадаадын хөрөнгө оруулалтад тус дөхөм үзүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрүүдийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, шинэ технологийг нэвтрүүлэх явдал байв. Бүсүүд дэх компаниудын анхаарлыг татахын тулд Тайвань гаалийн татвар хэрэглээний татвар, корпорацийн ашиг орлогын татвараас эдгээр компанийг чөлөөлөх аргыг сонгон авчээ. Үүний үр дүнд бүсүүдэд нарийн машин, электроник, пластикийн үйлдвэрлэл зэргийг багтаасан 270 гаруй үйлдвэр ажиллах болжээ. Тайваний туршилтын эхэн үед экспортын үйл явцыг эрхлэх чөлөөт бүсүүд нийт экспортоос олсон мөнгөний дийлэнх хэсгийг олж байлаа. 1967 оноос 1976 оны хооронд бүсүүд 2,3 тэрбум долларын экспортын бүтээгдэхүүн буюу Тайваний бүх экспортын бүтээгдэхүүн буюу Тайваний бүх экспортын 70 хувийг гаргаж байжээ.

БНХАУ-ын Шэньчжэний эдийн засгийн чөлөөт бүс нь дэлхийн хамгийн амжилттай ажиллаж буй бүсүүдийн нэгд тооцогддог. Яагаад гэвэл энэ бүс нь хөрөнгө оруулалтыг үйлдвэрлэлийн салбараар хязгаарлалгүй, мөн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэхэд нийтийн анхаарлыг татж чадсан ажээ. Энэ бүс нь Хятадад эвчлөөрөгдсөн зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг хэрэглэх туршилатыг явуулах, цаашид энэ туршилтын үр дүнг улс орны бусад районд дэлгэрүүлэхэд үйлчлэх зорилгоор байгуулагдсан бүс юм. Шэньчжэний бүсийг 1980 онд 327 хавтгай дөрвөлжин километр нутаг дээр байгуулсан бөгөөд 1990 он хүртэлх 10 жилд 512 сая долларын өртөгтэй хөрөнгө оруулалтын 569 төслийг өөртөө татаж чадаад 76 мянган ажлын байрыг бий болгожээ. 1990 онд энэхүү бүсэд 5 тэрбум экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Далайн чанадад оршин суудаг хятад хүмүүс эх орныхоо эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад Шэньчжэнь үйлчлэх зорилготой байсан, түүнээс ч амжилттай биелүүлж байгаа ажээ.

Зүүн өмнөд Азийн бүс нутгийн чухал төвүүдийн нэг болсон Сингапурийн хөгжил нь голдуу гадаад хөрөнгө оруулалтаар нэхцэлдсэн байна. Энэхүү хст-улс нь дотооддоо тодорхой арга хэмжээ авч

явуулан, татвар, хураамжийн доогуур төвшиннийг тогтоож, үйлдвэрлэл, худалдаа, ачих буулгах үйлчилгээ, санхүүгийн салбарт өрсөлдөөний нөхцөлд ажиллаж чадсанаар ийнхүү эдийн засгийн чөлөөт бүс болжээ. Сингапурт дэд бүтцийг байнга боловсронгуй болгож, үйлчилгээний зардлыг бүс нутгийн бусад орныхоос харьцангуй доогуур тогтоосон байна. 1985 оноос Сингапур урамшуулал, хөнгөлөлтний тусгай арга хэмжээний тусламжтайгаар эрдэм шинжилгээ зохион бүтээх туршилтын шийдлийг хөхүүлэн дэмжих, дотоод боловсруулалт нэвтрүүлэх замаар өндөр ашиг өгөх үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн ба бусад үйлчилгээ өөд тэмүүлэх хөдөлгөөнийг дэмжих талаар онцгой хүчин чармайлт тавьсан байна. Энэ бүхэн нь гадаад хөрөнгө оруулалтын өндөр төвшингийн үр дүн бөгөөд тэдгээрт онцгой ашигтай газар нутгийн байрлал онгоцны буудал их нэмэр болжээ.

Дээр дурдсан гурван улсын жишээнээс гадна Гонконг, Өмнөд Солонгос, Тайланд, Малази, Индонез зэрэг бусад орон эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл баримтлалыг өөр өөрийн нөхцөлд тохируулан амжилттай хэрэгжүүлсэн юм.

Энд дурдсанаас ургуулан өгүүлэхэд Ази тивийн Өмнөд, Зүүн өмнөд бүс нутагтай харьцуулбал Зүүн хойт бүс нутаг эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулан ашиглах явдлыг дөнгөж эхэлж байгаа бөгөөд энэ нь ч дурдсан чиглэлийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол өгч байгаагийн нэрлэл болж байна. Энэ бүс нутгийн орнууд биет дэд бүтэц төдийгүй, банк, даатгал, хууль зүй, хэв журмын асуудал, мэргэжлийн бусад үйлчилгээ, зам тээвэр зэрэг чухал чухал салбарын хөгжлөөр харьцангуй хоцрогдсоор байгаа юм. Эдгээр хоцрогдлыг даван туулахад эдийн засгийн чөлөөт бүс ихээхэн тус дөхөм үзүүлэх бөгөөд тэгэхэд бүс нутгийн стратегийн чухал ач холбогдолтой байрлал нь гадаадын хөрөнгө оруулалтыг өөртөө татаж, хожмын эдийн засгийн хөгжлийг азчрах баталгаа болж харахад үл чадна.

Газар нутгийн байрлал, байгалийн эрдэс баялаг зэрэг нь таатай нөхцөл бүрдүүлэх боловч улс орон бүр өөртөө таатай нөхцөлийг бэлтгэх талаар зохих нааштай алхам хийх нь чухал гэж үздэг юм байна. Бүс нутгийн улсуудын их багын ялгавар, дотоод хөгжлийн нарийн төвөгтэй асуудал зэргийг анхааран эдийн засгийн чөлөөт бүсийг өөрт тохирохуйцаар байгуулна гэдэг нь нийт улсын хэмжээгээр үл хийгдэх тийм өөрчлөлтүүдийг тэрхүү сонгосон бүсүүдэд хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Бүх нутгийн улс орон бүр хөгжлийн янз бүрийн шатанд байж, нийгэм-эдийн засгийн тогтолцоо нь байнга өөрчлөгдөж байдаг учраас нэг загварын чөлөөт бүс байгуулж болохгүй нь мэдээж. Иймээс зөвхөн экспорт эрхлэх гэх мэт аль нэг төрлийн бүс, харин бүх төрлийн эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах нь Зүүн хойт Азид илүү тохирох хамгийн сайн загвар болно гэж эрдэмтэн, мэргэжилтэн нар үздэг байна.

Эдүгээ БНХАУ, ОХУ, ЕНАСАУ эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүд байгуулах асуудлыг шийдвэрлэх практик аажмуудыг хийж байна. Гурван улсын анхаарлын төвд хил нийлсэн рэйондоо тус тус бүсийг байгуулахыг эрмэлзэх үү, эсвэл тэдгээрийг нийлүүдэн нэгэн бүс байгуулах уу гэдэг асуудал оршиж байна. Өнөөдөр ямар ч гэсэн гурван улсын бүсүүд хоорондоо зам тээвэр, холбоо харилцааны сайн системээр холбогдож гурван бүсийн хууль тогтоомж, дүрэм журмууд нь аль болохоор ижил төстэй байх нь чухал гэж үзэж байна. Тэргүүн ээлжинд төмөр, засмал, усан, агсаарын зам болон холбоо харилцааг сайжруулан, Сүйфеньхег Владивостоктой төмөр замаар, Хуньчинийг Посьеттэй, Ражин-Сонбоныг Жилин мужтай төмөр ба засмал замаар холбох жишээтэй асуудал яригдаж байна. Энэ нь худалдаа, хөрөнгө оруулалтын бололцоог ихэд хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх юм. Эх газрын усан буудлуудыг /жишээ нь Хуньчинд/ байгуулах нь Малайзи, Индонезид "хуурай газрын усан буудлуудыг" байгуулсан шиг Япон далайд гарах гарцыг нэмэгдүүлж, хөгжилд тус дөхөм үзүүлэх үйл явдал болох юм. Капитал хөрөнгө дэлхийн хэмжээгээр дутагдаж байгаа нөхцөлд ийм

төрлийн хөрөнгө оруулалт нь бүс нутагт хөгжлийг дэмжих, хөрөнгө хэмнэх арга зам болох талтай юм.

Азийг эргэн тойрон Гонконг, Шеньчжен, Сингапур, Малайз, Индонез зэрэгт хэднй нь байгуулагдсан чөлөөт эдийн засаг ба худалдааны бүсүүдтэй өрсөлдөхийн тулд Зүүн хойт Ази д тэдгээртэй ойролцоо бүхүү илүү хөгжөлттэй хууль тогтоомж, санхүүгийн хөрөнгө оруулалтын нөхцөлийг буй болгох хэрэгтэй аж. Ялангуяа газар өмчлөл буюу түрээслэл, албан татвар, гааль, иммиграци, мөнгө солилт, орлогоо гадагш гуйвуулах зөвшөөрөл, ажиллах хүчний хөдөлгөөн зэргийн талаархи дүрэм журам нь нэн чухал байх болно. Хөрөнгө оруулагчид ганц Ази тиад ч биш, дэлхий далаар шинэж сонгох эргэн бололцоотой байдаг. Хэрэв зохих тохиромжтой нөхцөлийг бий болгохгүй юм бол Зүүн хойт Азид байгуулах гэж буй эдийн засгийн чөлөөт бүсийн хөдөлгөөнийг өрнүүлэхэд хэрэгтэй зохих хэмжээний хөрөнгө оруулалтыг өөрийн талд татах явдал амаргүй байх юм.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс боловсруулсан "Түмэн гол нутгийн хөгжлийн хөтөлбөр" нь бүс нутгийн бүх улс орон хамтран ург хугацааны төлөвлөгөөг хөдөлгөөн тохиролцоо бололцоог бий болгосноор чухал ач холбогдолтой үйл хэрэг боллоо. Тиймээс урт, богино хугацааны төлөвлөгөөнүүдийг аль болох эртнээс зохицуулах явдал нэн чухал юм. Дэд бүтцийн сул талыг анхаарахгүй байж болохгүй. Бизнесийн үйлчилгээ явуулах, захиргааны байгууллагууд байгуулах, сургах ба дайтган сургах зэрэг нь байгуулж буй бүх зүйлийн гол сүнс байх болно. Эдгээр зүйлсийг хөгжүүлэх явдал улс бүр усан боомт, онгоцны буудал, төмөр зам зэрэг байгаа бүх дэд бүтцийг хөгжүүлж, тэгэхдээ шинээр бэрхж босгохоор барахгүй, "байгаа хүчин чадал" үр ашгийг нь байнга дээшлүүлж байх нь чухал юм.

Чөлөөт бүсийг байгуулах хэрэгдээ ихтэй Зүүн хойт Азийн бүс нутагт багтаж буй Монгол Улсад ийм хэрэгдээ улам ч их биз. Монголд эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах ажиллуулахад: - Хууль зүйн болон хэв журмын тогтолцоо: - санхүүгийн байгууллагууд: - мэргэжлийн үйлчилгээ, - биет дэд бүтэц: - эдийн засгийн тогтвортой байдал, - улс төрийн тогтвортой байдал, - эдийн засгийн нээлттэй боллого, - хөгжилд зориулсан албан ёсны тусламж /ODA/ зэрэг хүчин зүйл Зүүн хойт Азийнхаас ч илүүтэй шаардагдах болов уу. Мөнхэй улс эдгээр зүйлээр дутагдаж байгаагийн дээр байгалийн байгалийг боловсруулах, импорт орлуулах, экспорт баримжаалан үйлдвэрлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, мэргэжлийн үйлчилгээг нэвтрүүлэх хэрэгдээ шаардлага нэн ихтэй байгаа билээ. Тиймээс улс орны сонгож авсан нутаг дэвсгэрт эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, түүнийг дэд бүтцийн хөгжлийг төвлөрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтад тус дөхөм үзүүлэх зорилгыг шийдвэрлэх хэрэгсэл болгон ашиглах нь эдийн засгийн хөгжлийг хурдасгах, бүс нутгийн орнуудтай гадаад эдийн засгийн харилцааг өргөтгөхөд сайн нөлөө үзүүлэх нь эргэлзээгүй.

Одоогоор Монгол оронд эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах тухай төр, засгийн ч илдээр хариуцсан гараагүй боловч түүнийг /улсын умард, дорнод, төв хэсгийн зарим нутаг дэвсгэрт/ байгуулах үзэл санааг олон нийтээс дэмжүүлж засаг төрийн холбогдох байгууллагууд судлан боловсруулах болсон байна. Төр, засгийн барим бичгүүдэд үүний анхны тусгалууд үзэгдэх боллоо. 1991 оны 12 дугаар сарын сүүлчээр Монгол, Оросын Засгийн газар хоорондын хулаалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны анхдугаар хуралдааны үеэр Монголын Сэлэнгэ аймаг, Буриадны Уиагтын дүүрэгт эдийн засгийн чөлөөт бүс байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож, хуралдаанд оролцсон Чята мужийн төлөөлөгчид Орос-Монголын хянд дээр худалдааны чөлөөт бүс нээх сонирхлоо Монголын тал илэрхийлбэл бид эвч хэлэлцэхэд бэлэн гэж мэдэгдсэн билээ.

Монгол Улсын ерөнхийлөгч Дорнод аймагт 1992 оны сүүлчээр явах үедээ эдийн засгийн чөлөөт бүсийн асуудлыг хөндөн ярьж, Дорнод

аймгийн зарим хэсэгт үйлдвэрлэл, худалдааны чөлөөт бүс байж болохыг тэмдэглэсэн. Ерөнхийлөгч хэлэхдээ: эдийн засгийн чөлөөт бүс байгуулах явдал нь улс орны эдийн засгийн аюулгүй байдал, үндэний эрх ашгийг хангах, үр ашигтай зохион байгуулахыг шаардах нарийн төвөгтэй асуудал тул тэр талаар төрийн нэгдсэн бодлого зохицуулалт хэрэгтэй гээд "эдийн засгийн чөлөөт бүс бол манай улсын тунхагласан нээлттэй гадаад бодлогын эдийн засгийн хүрээгээ хэрэгжүүлэх нэгэн арга хэлбэр юм" гэдгийг онцолсон юм.

Монгол улс өөрийн нутгийн сонгож авсан тодорхой районуудад эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулан ашиглах зохих потенциалтай. Манай холбогдох байгууллага, мэргэжилтэн нар чөлөөт бүс байгуулах бололцоо, түүнийг онцлогийг гадагдын туршлагатай хөслөн судалж, Засгийн газрын шийдвэрийн үндсэн дээр уг ажлыг зохион байгуулах явдал чухал зорилт болон тавигдаж байна.

1. "Зүүн хойт Азийн эрэг хавь нутгийн эдийн засгийн хөгжлийн асуудлаар хийсэн бага хурлын протокол" 1991. ҮШ. 29-31. Чанчун, Хятад улс. 1992. ҮI сар

2. "Пхеньяны олон улсын бага хурал ба хэргийн аялал" 1992. IV. 29-Ү. 4. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс 1992. ҮШ сар.

3. "Зүүн хойт Ази дахь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа" олон улсын бага хурлын материал: Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай асуудлаар Ш. Кобгяшийн тавьсан илтгэл: Өмнөд Солонгосын шууд хөрөнгө оруулалт ба Зүүн хойт Азийн эдийн засгийн бүс хэмээх Н. Касани илтгэл. 1992. ҮШ. 24-28. Владивосток. Орос улс.

4. Е. Кожокин, эдийн засгийн чөлөөт бүс ба бүс нутгийн бодлого. "Олон улсын амьдрал" сэтгүүл, № 10. 1991

5. "Засгийн газрын мэдээ" сонин, 1992. ҮI сар. № 19

6. "Ардын эрх" сонин, 1992. ХП. 04. № 182